| C01 | **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,565,059,217.41** | | **618,150,859.60** | **3,183,210,077.01** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,565,059,217.41 | | 618,150,859.60 | 3,183,210,077.01 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 5,562,254,520.64 | 5,562,254,520.64 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,565,059,217.41** | | **6,180,405,380.24** | **8,745,464,597.65** |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,565,059,217.41** | | **6,180,405,380.24** | **8,745,464,597.65** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,565,059,217.41 | | 6,180,405,380.24 | 8,745,464,597.65 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 67,302,260.00 | | | 67,302,260.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (3,097,864,267.78) | (3,097,864,267.78) |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,632,361,477.41** | | **3,082,541,112.46** | **5,714,902,589.87** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 32,164,781,600.00 | 16,134,960,099.68 | 16,029,821,500.32 | 50.2 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 32,164,781,600.00 | 16,134,960,099.68 | 16,029,821,500.32 | 50.2 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 32,093,160,900.00 | 16,063,779,899.68 | 16,029,381,000.32 | 50.1 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 495,909,400.00 | 463,003,314.00 | 32,906,086.00 | 93.4 |
| 210101 | Үндсэн цалин | 335,383,500.00 | 302,504,945.00 | 32,878,555.00 | 90.2 |
| 210102 | Нэмэгдэл | 68,591,400.00 | 79,398,913.00 | (10,807,513.00) | 115.8 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 47,190,000.00 | 46,218,000.00 | 972,000.00 | 97.9 |
| 210104 | Урамшуулал | 44,744,500.00 | 34,881,456.00 | 9,863,044.00 | 78.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 66,947,800.00 | 60,454,093.14 | 6,493,706.86 | 90.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,111,400.00 | 40,749,675.54 | 6,361,724.46 | 86.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,959,100.00 | 4,989,004.15 | (29,904.15) | 100.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,967,300.00 | 3,924,123.98 | 43,176.02 | 98.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 991,800.00 | 981,083.17 | 10,716.83 | 98.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,918,200.00 | 9,810,206.30 | 107,993.70 | 98.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 52,529,000.00 | 41,464,875.80 | 11,064,124.20 | 78.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,017,000.00 | 10,227,875.80 | 10,789,124.20 | 48.7 |
| 210304 | Байрны түрээс | 31,512,000.00 | 31,237,000.00 | 275,000.00 | 99.1 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,769,742,800.00 | 9,958,360,452.51 | 10,811,382,347.49 | 47.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,960,000.00 | 6,365,370.00 | 594,630.00 | 91.5 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,754,304,400.00 | 9,943,955,542.18 | 10,810,348,857.82 | 47.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,478,400.00 | 7,039,992.33 | 438,407.67 | 94.1 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.00 | 999,548.00 | 452.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 11,016,000.00 | 9,680,500.00 | 1,335,500.00 | 87.9 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 11,016,000.00 | 9,680,500.00 | 1,335,500.00 | 87.9 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 177,526,500.00 | 52,796,200.00 | 124,730,300.00 | 29.7 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 52,347,800.00 | 52,271,200.00 | 76,600.00 | 99.9 |
| 210604 | Урсгал засвар | 125,178,700.00 | 525,000.00 | 124,653,700.00 | 0.4 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 200,000.00 | 106,000.00 | 94,000.00 | 53.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 200,000.00 | 106,000.00 | 94,000.00 | 53.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 617,189,400.00 | 465,195,577.13 | 151,993,822.87 | 75.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 600,000,000.00 | 451,054,308.13 | 148,945,691.87 | 75.2 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,760,000.00 | 3,490,536.00 | 269,464.00 | 92.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,380,000.00 | 211,100.00 | 1,168,900.00 | 15.3 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 500,000.00 | 99,000.00 | 401,000.00 | 19.8 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 132,000.00 | 132,000.00 | - | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 11,417,400.00 | 10,208,633.00 | 1,208,767.00 | 89.4 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,902,100,000.00 | 5,012,718,887.10 | 4,889,381,112.90 | 50.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,900,000,000.00 | 5,011,818,887.10 | 4,888,181,112.90 | 50.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,100,000.00 | 900,000.00 | 1,200,000.00 | 42.9 |
| **212** | **ТАТААС** | 66,620,700.00 | 66,620,700.00 | - | 100.0 |
| **2121** | **Төрийн өмчит байгууллагад олгох татаас** | 66,620,700.00 | 66,620,700.00 | - | 100.0 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 66,620,700.00 | 66,620,700.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,000,000.00 | 4,559,500.00 | 440,500.00 | 91.2 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,000,000.00 | 4,559,500.00 | 440,500.00 | 91.2 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,000,000.00 | 4,559,500.00 | 440,500.00 | 91.2 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 32,164,781,600.00 | 16,134,960,099.68 | 16,029,821,500.32 | 50.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 32,154,781,600.00 | 16,122,323,092.68 | 16,032,458,507.32 | 50.1 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 32,154,781,600.00 | 16,122,323,092.68 | 16,032,458,507.32 | 50.1 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 10,000,000.00 | 12,637,007.00 | (2,637,007.00) | 126.4 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,000,000.00 | 12,637,007.00 | (2,637,007.00) | 126.4 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 39 | 39 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 2 | 2 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18 | 18 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 19 | 19 | - | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **39** | **39** | - | 100.0 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 20 | 20 | - | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 19 | 19 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,715,760,906.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,715,760,906.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,715,760,906.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,471,227,175.07 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,471,227,175.07 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,244,533,730.93 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,244,533,730.93 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **5,715,760,906.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **5,715,760,906.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,715,760,906.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Б.Пүрэвсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилт, анхан шатны баримтын бүрдлийг хангах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Нийслэл дэх Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Долгорсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 1/39 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын үйл ажиллагааны чиг үүргийг байгууллагын дүрэмд "*Агаарын тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих; агаар бохирдуулах бодисын хаягдал, агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эх үүсвэрийн тооллогыг мэргэжлийн албаны орон нутаг дахь салбартай хамтран нутаг дэвсгэртээ зохион байгуулах*" гэж тодорхойлсон.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

Нийслэлийн Дотоод аудитын газар "Аудитын, хяналт шалгалтын 2020 оны төлөвлөгөө"-ний дагуу Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2019 он болон 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд дотоод аудит хэрэгжүүлсэн.

Аудитаар 455,114.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага тогтоосон байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 7,600,147.5 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 152,002.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 503,440.8 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардлын дүн өмнөх оноос 3.3 дахин нэмэгдсэнтэй холбоотой.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,326,943.6 мянган төгрөгөөр буюу 51.5 хувиар буурсан. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 203,565.3 | 129,017.3 | (74,548.0) |
| Авлага | 6,861,658.1 | 187,959.3 | (6,673,698.8) |
| Урьдчилгаа | 2,737,899.1 | 68,680.0 | (2,669,219.1) |
| Бараа материал | 265,063.0 | 279,831.4 | 14,768.4 |
| Үндсэн хөрөнгө | 2,210,049.4 | 5,285,803.4 | 3,075,753.9 |
| **Нийт хөрөнгө** | **12,278,234.9** | **5,951,291.3** | **(6,326,943.6)** |
| Өр төлбөр | 3,532,770.3 | 236,388.7 | (3,296,381.6) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 8,745,464.6 | 5,714,902.6 | (3,030,562.0) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **12,278,234.9** | **5,951,291.3** | **(6,326,943.6)** |

Мөнгөн хөрөнгийн дансанд хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын барьцаа төвлөрдөг бөгөөд тайлант онд 19,220.9 мянган төгрөгийн барьцаа төвлөрүүлж, 93,768.9 мянган төгрөгийн барьцаа чөлөөлсөн.

Тайлант онд авлагын үлдэгдэл 6,673,698.8 мянган төгрөгөөр буурч, 2019 онд үүссэн Таван толгой түлш ХХК-иас авах 67,592.4 мянга, 2020 онд үүссэн нийслэлийн Төрийн сангаас авах 112,019.1 мянга, БОАЖЯ-аас авах 7,500.0 мянга, бусад 847.8 мянга, нийт 187,959.3 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1253 дугаар захирамжаар хэвлэл мэдээллийн 17 байгууллагатай 2020-2021 онд хамтран ажиллах гэрээ байгуулаад урьдчилгаанд 68,680.0 мянган төгрөг төлснийг урьдчилгаа дансанд бүртгэсэн.

Бараа материал төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 3,744,366.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 3,625,723.9 мянга */үүний 3,508,737.5 мянган төгрөг нь дүүргүүдэд тараасан угаарын хий мэдрэгч/,* байгууллагын даргын тушаалаар акталсан 103,873.8 мянга, нийт 3,729,597.7 мянган төгрөгөөр буурсан. Тайлант хугацаанд нэмэгдсэн болон зарцуулсан бараа материалын дүн өмнөх оноос 11-9 дахин өссөн нь дүүргүүдэд 200.0

мянган ширхэг угаарын хий мэдрэгч тараасан, Ковид-19 цар тахлаас урьдчилсан сэргийлэх зорилгоор 39,074.5 мянган төгрөгийн маск, гар ариутгагч, бээлий зэргийг худалдан авч зарцуулсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын шийдвэрээр орлогод авсан 4 ширхэг сайжруулсан түлш нөөцлөх агуулахын үнэ 2,984,067.5 мянга, хөрөнгө оруулалтын зардлаас суурин харуулын тоног төхөөрөмжийн шинэчлэлд 365,454.7 мянга, гэрчилгээ нь шинээр гарсан газрын 67,302.3 мянга, төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийн 57,069.9 мянга, нийт 3,473,894.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн.

Өр төлбөрийн дансанд хөрөнгө оруулалтын барьцаа 129,017.3 мянга, аялал жуулчлалын компанид төлөх 106,400.0 мянга, сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлтийн тооцоо 971.4 мянга, нийт 236,388.7 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнасан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл нь 2,632,361.5 мянган төгрөгийн засгийн газрын сан, 3,082,541.1 мянган төгрөгийн хуримтлагдсан үр дүнгээс бүрдсэн.

Тайлант оны үйл ажиллагааны орлого 67.7 хувиар, зардал 3.3 дахин нэмэгдэхэд сайжруулсан шахмал түлшний тээврийн болон борлуулагч ажиллуулах зардал тайлант оны төсөвт тусгагдсан, өмнөх оны авлагаас угаарын хий мэдрэгчийн үнэ төлсөн зэрэг нь нөлөөлсөн.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,533,834.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,533,834.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 30,630,946.9 мянган төгрөгөөр буюу 20 дахин нэмэгдүүлж 32,164,781.6 мянган төгрөгөөр баталсан байна. Засгийн газрын 2019 оны 270 дугаар тогтоолоор Нийслэлийн гэр хорооллын иргэдийг сайжруулсан шахмал түлшээр хангах ажлын хүрээнд “Таван толгой түлш” ХХК-ийн агуулахаас шахмал түлш худалдан борлуулах цэг хүртэлх тээврийн болон худалдан борлуулагч ажиллуулах зардлыг зохих журмын дагуу санхүүжүүлэхийг нийслэлийн Засаг даргад даалгасантай холбоотойгоор Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын төсөвт дээрх зардлуудыг тусгасан.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 32,164,781.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 32,154,781.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 10,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 16,186,973.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 12,637.0 мянган төгрөг, нийт 16,199,610.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 16,134,960.1 мянган төгрөгийг зарцуулж 64,650.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 16,134,960.1 мянган төгрөг буюу 50.2 хувьтай байгаа нь сайжруулсан шахмал түлшний тээврийн зардал, түлш борлуулагчийн зардал төлөвлөснөөс бага гарсантай холбоотой.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны төсөв батлах тухай тогтоолд зааснаар 2020 онд 10,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 12,637.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 126.4 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт 2.* Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 10,000.0 | 12,316.7 | 2,316.7 | 123.2 |
| Туслах үйл ажиллагааны орлого | | 320.3 | 320.3 | 3.2 |
| **Нийт дүн** | **10,000.0** | **12,637.0** | **2,637.0** | **126.4** |

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

*Хүснэгт 3.* Нэмэлт санхүүжилтийн дансны тооцоо

/мянган төгрөг/

| № | Бэлтгэн нийлүүлэгч | Орлого | Зарцуулалт | Үлдэгдэл | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | 2,481,075.0 | 2,467,983.0 | 13,092.0 | Хяналтын ажилтнуудын урамшуулал |
| 2 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | 17,500.0 | 24,972.9 | (7,472.9) | Авлагаар тайлагнасан. |
| 3 | Нийслэлийн Төрийн сан | 3,329,205.0 | 3,222,805.0 | 106,400.0 | Сайжруулсан түлш тээвэрлэлтийн зардал |
| 4 | Ц.Буянбадрах | 2,707.0 | | 2,707.0 | Угаарын хий мэдрэгчийн тооцооны зөрүү |
| | **НИЙТ ДҮН** | **5,830,487.0** | **5,715,760.9** | **114,726.1** | |

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 5,830,487.0 мянган төгрөгийн орлого бүрдсэнээс 5,715,760.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 114,726.1 мянган төгрөгийг нийслэлийн Төрийн санд төвлөрүүлсэн.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 813 мэдээллээс хугацаандаа оруулсан 788 мэдээлэл, хугацаа хоцроосон 22 мэдээлэл, 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 582,179.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 83,871.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 67,271.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 10,870.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 420,166.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого 64,650.4 мянга, зардал 19,220.9 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасныг аудитын явцад залруулсан.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 498,308.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 67,271.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 10,870.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Өмнөх онд үүссэн 67,271.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлант оны тооцооноос хорогдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", УСНББОУС-ын 1-ийн 27 зүйл: "*...үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг...*" заалттай нийцэхгүй, "*үнэн зөв байдал*", "*эрх ба үүрэг*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төлбөрийн акт тогтоов.

2. Нийт 3,870.0 мянган төгрөгийн авлага, 7,000.0 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", УСНББОУС-ын 1-ийн 27 зүйл: "*...үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг...*" заалтыг хэрэгжүүлээгүй, "*үнэн зөв байдал*", "*иж бүрэн байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Албан шаардлага хүргүүлэв.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 420,166.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар аж ахуйн нэгжүүдэд олгосон сайжруулсан шахмал түлшний тээврийн зардал, Таван толгой түлш ХХК-д олгосон борлуулалтын урамшууллын тооцоог цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитын явцад түүвэрт хамруулан шалгаж амжаагүй ба дээрх асуудлыг 2021 оны завсрын аудитаар нөхөн шалгах болно.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***Зардал данстай холбоотой асуудал***

*1.1 Илрүүлэлт:*
Тайлант хугацаанд цахим и-баримтын дүнгээс бараа материал, ажил үйлчилгээний 351,486.7 мянган төгрөгийн төлбөрийг зөрүүтэй шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2, 17.6 дахь заалтуудыг зөрчсөн.

*1.2 Эрсдэл:*
Төсөв үндэслэлгүй төлөвлөгдөх, хяналтгүй зарцуулагдах

*1.3 Өгсөн зөвлөмж:*
Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтуудыг мөрдөж ажиллах

*1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*
ТШЗ-ийн зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

***Шилэн данстай холбоотой асуудал***

*2.1 Илрүүлэлт:*
Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл дутуу байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.5 дахь заалтуудыг зөрчсөн.
*2.2 Эрсдэл:*
Шилэн дансны тухай хууль хэрэгжихгүй байх

*2.3 Өгсөн зөвлөмж:*
Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.”, 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалтыг мөрдөж ажиллах

*2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*
ТШЗ-ийн зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

***Балансын данстай холбоотой асуудал***

*3.1 Илрүүлэлт:*
Тайлант онд ААН-д 68,680.0 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлж авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчсөн.

*3.2 Эрсдэл:*
Төсөв хэтрүүлэн зарцуулах

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллах

*3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*
ТШЗ-ийн зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | *Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит* | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021.02.25 | | | НТАГ-2021/406/СТА-ТШЗ |

| Шалгагдсан байгууллагын нэр: | *Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар* | Мянган төгрөг |
|---|---|---|

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого 64,650.4 мянган төгрөгөөр, зардал 19,220.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. | 83,871.3 | Залруулсан | Дарга, Нягтлан бодогч | Б.Пүрэвсүрэн, Б.Байгалмаа |
| 2 | Тайлант хугацаанд цахим и-баримтын дүнгээс бараа материал, ажил үйлчилгээний төлбөрийг зөрүүтэй шилжүүлсэн. | 351,486.7 | Зөвлөмж өгөв | Дарга, Нягтлан бодогч | Б.Пүрэвсүрэн, Б.Байгалмаа |
| 3 | Тайлант онд ААН-д 68,680.0 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлж авлага үүсгэсэн. | 68,680.0 | Зөвлөмж өгөв | Дарга, Нягтлан бодогч | Б.Пүрэвсүрэн, Б.Байгалмаа |
| 4 | Нийт 3,870.0 мянган төгрөгийн авлага, 7,000.0 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй. | 10,870.0 | Албан шаардлага өгөв | Дарга, Нягтлан бодогч | Б.Пүрэвсүрэн, Б.Байгалмаа |
| 5 | Өмнөх онд үүссэн авлагыг барагдуулаагүй, тайлант оны тооцооноос хорогдуулаагүй. | 67,271.5 | Төлбөрийн акт тогтоов | Дарга, Нягтлан бодогч | Б.Пүрэвсүрэн, Б.Байгалмаа |
| 6 | Шилэн дансны цахим хуудсанд 868,640.4 мянган төгрөгийн мэдээлэл дутуу байршуулсан. | - | Зөвлөмж өгөв | Дарга, Нягтлан бодогч | Б.Пүрэвсүрэн, Б.Байгалмаа |
| | **ДҮН** | **582,179.5** | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**Хянасан:**

Аудитын 2 дугаар хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер З.Мөнхбаяр

Аудитын менежер Д.Отгонбаяр

**Бэлтгэсэн:**

Ахлах аудитор Г.Долгорсүрэн